

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал 7	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	20
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/311  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалтай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнг/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн.

Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал

Батлагдсан орон тоог хэтрүүлсэн, хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өөрийн орлогыг кассанд бэлнээр авч зарцуулсан зэрэг нийт 43,020.5 мянган төгрөгийн материаллаг алдаа, зөрчил нь санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төвийн захирал Ц.Уранчимэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 16-ны өдрүүдэд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор А.Мөнхцэцэг, З.Цэцгээ, Я.Батбаяр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Арьсны өвчин судлалын үндэсний төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Пийк Ом Аудит” ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 38 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь Монгол улсын хэмжээнд арьсны өвчин, эмчилгээний гоо заслын чиглэлээр оношилгоо, эмчилгээг үйлчлүүлэгч бүрд чирэгдэлгүй, хүртээмжтэй, чанартай үзүүлэхийн төлөө эрүүл мэндийн салбарын дэвшүүлсэн бодлогыг хэрэгжүүлэн ажиллана гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Монгол улсын хэмжээнд арьс харшил, эмчилгээний гоо заслын төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчдэд тасралтгүй хөнгөн шуурхай, чанартай үзүүлэхийн зэрэгцээ арьс гоо засалч эмч нарыг мэргэжлийн удирдлагаар хангах, төгсөлтийн дараах албан болон албан бус сургалтуудыг зохион байгуулах, нийт хүн амыг арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг Монгол улсын хэмжээнд явуулдаг клиникийн бааз эмнэлэг юм. Арьсны өвчин судлалын үндэсний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Арьсны өвчин судлалын үндэсний төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Emerald” програм хангамж ашигладаг байна.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Арьсны өвчин судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 1.0 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь үр дүнгийн тайланд тухайн байгууллагын тайлант жилийн үйл ажиллагаатай холбоотой зардал бодитоор илэрхийлэгддэгтэй холбоотой юм.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,346,808.4 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 33,468.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 17 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 12 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал				/мянган төгрөгөөр/	
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар	
1	Зөвлөмж өгсөн	3	220.0		
2	Төлбөрийн акт тогтоосон	1	1,528.7		
3	Албан шаардлага өгсөн	7	41,271.8		
Дүн		11	43,020.5		

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрч акт, албан шаардлага тавигдсан болон залруулсан алдааны дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тус төвийн захирлын ээлжийн амралтын олговор, 14 хоногийн цалинг давхардуулан нийт 1,528.7 мянган төгрөгийг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 "Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

2. Удирдлагын багийн гишүүдэд урамшуулал олгоходоо холбогдох тушаал шийдвэрээс 660.0 мянган төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөх;

3. Тайлант онд сахилгын шийтгэлтэй 2 албан хаагчид улирлын үр дүнгийн урамшуулал 571.9 мянган төгрөг олгосон нь Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 150 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.6 "Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 71-ээс доош хувьтай байгаа тохиолдолд тухайн албан хаагчид улирлын урамшил олгохгүй", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөх;

4. Батлагдсан орон тооноос илүү гэрээт ажилтанд цалин олгосон болон хавсран ажилласны нэмэгдэлд нийт 2,246.9 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 2.2 "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 6 дугаар зүйлийн 4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөх;

5. Түлээ нүүрсний хөнгөлөлтийг орон байрны нөхцөлийг харгалзахгүйгээр ажилчдад нийт 14,800.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", хамтын гэрээний 4.5 "Гэрт болон гэр хороололд төвлөрсөн халаалтын системд холбогдоогүй орон сууцанд амьдардаг ажилтанд түлээ, нүүрсний хөнгөлөлт олгох асуудлыг тусгаж шийдвэрлэж болно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөх;

6. 2018 оны 5 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр бус шийдвэрийг үндэслэн ажилчдын хоолны зардалд 19,375.2 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөх;

7. Статистикч их эмч, дүн бүртгэлийн бага эмч нарт улирлын үр дүнгийн урамшуулал, гүйцэтгэж буй ажлын урамшууллыг давхцуулан, ижил үзүүлэлтээр үнэлж 1,498.4 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөх;

8. “Аварга тосон” сувиллын эрхийн бичгийн 2,119.4 мянган төгрөгийн орлогыг кассаар авч шууд зарцуулсан нь Төсвийн байгууллагын мөнгөн кассын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6 “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөх;

9. Тайлант онд ашиглалтын зардлын нийт 118,121.3 мянган төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т “Төсвийн байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын “Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын зардал бүлгийн 3.2, 3.10 дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв;

10. Тайлант онд худалдан авсан 24,143.7 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлээс хасаж, зардлаар тайлагнасан нь УСНББОУС-12 “Бараа материал”-ын 9 дэх “Бараа материалд дараах зүйл орно”: (б)-д “Үйлчилгээ үзүүлэхэд хуваарилагдах эсвэл хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа” гэж тодорхойлсон заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв;

11. Тайлант онд 3,000.0 мянган төгрөгийн өртөгтэй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Номын фонд дансанд бүртгэсэн нь Сангийн сайд 2006 оны 388 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.47 “Биет шинж чанаргүй, харьцангуй урт хугацаанд ашиглагддаг, эзэмшигчдэдээ эрх, давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу тал олгодог хөрөнгийг биет бус хөрөнгө гэнэ” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв;

12. Өмнөх аудитын зөвлөмжийн дагуу зардалд тайлагнасан үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд залруулга хийхдээ хөрөнгийн орлого дансанд бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын Төсөвт байгууллагад мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 7 дугаар зүйлийн 7.3-д “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, суурь алдааны залруулгыг хуримтлагдсан үр дүнгийн тайлант онд залруулах замаар тусган харуулна” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

## **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Аудитын явцад хойшид анхаарах дараах чухал асуудлууд гарлаа. Үүнд:

- Тайлант онд нийгмийн эрүүл мэндийн ажилтан ажиллуулж 5,183.2 мянган төгрөгийн цалин олгосон. Хэдийгээр үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж батлагдаагүй орон тоонд хүн ажиллуулах хэрэгцээ гарч байгаа боловч хууль тогтоомжийн хүрээнд ажиллах шаардлагатай.
- Ажиллагсдын гарт олгох цалингийн жагсаалтыг банкны теллерийн тамга тэмдгээр баталгаажуулж санхүүгийн баримтад хавсаргаагүй байна. Энэ нь хүмүүсийн цалин гарт үнэн зөвөөр олгогдож байгаа эсэхийг хянах боломжгүй байдал үүсгэх эрсдэлтэй.

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэхь заалтын дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэхь заалтын дагуу төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 3,075,415.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 3,074,059.6 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь урсгал зардлын хэмнэлтээс шалтгаалжээ.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Арьсны өвчин судлалын үндэсний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “www.shilendans.gov.mn” цахим хуудсаар “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр ил тод мэдээлж ажилласан байна. Тухайлбал 27 удаагийн нийт 2,628,397.6 мянган төгрөгийн орлогын мэдээ, 63 удаагийн 550,803.0 мянган төгрөгийн зарлагын мэдээг Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 72,7 хувьтай байна.

Тайлант онд дараах зөвлөмж хэрэгжээгүй байна. Үүнд:

Байгууллагын үйл ажиллагаанд зориулсан худалдан авалтын 593.0 мянган төгрөгийн и-баримт нь сугалааны дугаар бүхий иргэнд олгогдсон баримт байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Давтагдан гарсан 24,143.7 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 2,119.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага өгсөн.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Арьсны өвчин судлалын үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **Зардлын данстай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар 60.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.2 “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 6 дугаар зүйлийн 4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

##### **1.2. Эрсдэл:**

Хууль тогтоомж зөрчигдөх, төсвийн хөрөнгө үрэгдэх эрсдэл үүсгэж байна.

##### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах.

##### **1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

##### **2.1. Илрүүлэлт:**

Дуудлагаар ажилласан эмч, сувилагч нарын нэрсийг дуудлагын журналтай тулгахад зөрүүтэй, тэдэнд 160.0 мянган төгрөгийг олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх,

санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**2.2. Эрсдэл:**

Мөнгөн кассын ажиллуулах журмыг мөрдөж ажиллаагүйгээс төсвийн хөрөнгө зориулалт бусаар ашиглах эрсдэлийг үүсгэж байна.

**2.3. Өгсөн зөвлөмж:**

Алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

**3. Үйл ажиллагаатай холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:**

Тухайн байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээнд Засгийн газрын сангийн хэмжээг тусгаагүй, удирдлагын өөрчлөлт, томилгоог тэмдэглээгүй, нэмэгдсэн харилцах дансыг бүртгээгүй зэргээр 2003 оноос хойш мэдээлэл шинэчлээгүй байгаа нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 1.3. “Хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**3.2. Эрсдэл:**

Хууль тогтоомж зөрчигдөх.

**3.3. Өгсөн зөвлөмж:**

